

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шинэ мөрөн худалдааны төв” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2026/023/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Ц.Чагнаадорж

Утас: 99387994 Цахим хаяг: chagnaadorjts@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь
салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	5-9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....	10-16
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. Аудитын илрүүлэлт	19-21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
ОНӨҮГ	Орон Нутгийн Өмчит Үйлдвэрийн Газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03. 16 № 01/292
танай _____-ны № _____-т

“ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ
ТӨВ” ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.БАЯРМАГНАЙ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор 4,636,616.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 1,688,695.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэлээс хассан нь тус байгууллагын барилга шатсантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 71,071.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 16,922.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдааг залруулж, 54,149.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03. 16 № 01/292
танай _____-ны № _____-т

“ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ
ТӨВ” ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.БАЯРМАГНАЙ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор 4,636,616.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 1,688,695.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэлээс хассан нь тус байгууллагын барилга шатсантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 71,071.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 16,922.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдааг залруулж, 54,149.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Тус компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлдэг байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	106,140,071.73	166,491.89
1.1.2	Дансны авлага	41,432,425.01	37,888,625.01
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа .материал	103,171,674.73	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	250,744,171.48	38,055,116.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,192,084,323.79	0.00
1.2.2	Биет бус хөрөнгө	104,050,000.00	1,320,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,296,134,323.79	1,320,000.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,546,878,495.27	39,375,116.90
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,023,333.01	3,023,333.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	37,170,357.88	22,107,935.34
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	1,707,431.17
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	40,193,690.89	26,838,699.51
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	40,193,690.89	26,838,699.51
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	5,468,800,000.00	5,468,800,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	804,442,672.00	804,442,672.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(766,557,867.62)	(6,260,706,254.60)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,506,684,804.38	12,536,417.40
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	5,546,878,495.27	39,375,116.91

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	616,166,264.44	166,259,234.55
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	616,166,264.44	166,259,234.55

4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	689,969,253.96	702,634,177.25
11	Санхүүгийн зардал	250,792.00	90,099.40
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(9,724,053.03)	(4,976,414,314.61)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(83,777,834.55)	(5,512,879,356.72)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(83,777,834.55)	(5,512,879,356.72)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(83,777,834.55)	(5,512,879,356.72)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(83,777,834.55)	(5,512,879,356.72)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
6	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	623,203,101.86	191,818,964.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	614,087,791.86	191,818,964.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтын орлого		
	Бусад мөнгөн орлого	9,115,310.00	
1.2	Мөнгөн зарлага (-)	560,744,331.23	297,918,143.84
	Ажиллагчдад төлсөн	236,618,143.90	138,345,085.20
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	53,697,093.33	35,202,129.37
	Бараа материал худалдан авахад төлсөн	67,820,615.00	22,136,712.01
	Ашиглалтын зардалд төлсөн	137,587,385.94	72,218,786.67

	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд гөлсөн	9,500,300.00	3,499,000.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	48,774,793.06	16,036,430.59
	Даатгалын төлбөрт төлсөн	5,146,000.00	2,000,000.00
	Бусад мөнгөн зарлага	1,600,000.00	8,480,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	62,458,770.63	(106,099,179.84)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,300,000.00	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,300,000.00	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,300,000.00)	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,158,770.63	(106,099,179.84)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	106,841,569.99	106,140,071.73
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,119,684.62	166,491.89

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	5,461,000,000.00	264,242,100.00	(506,283,281.36)	5,218,958,818.64
Залруулсан үлдэгдэл		540,200,572.00		540,200,572.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(83,777,834.55)	(83,777,834.55)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт	7,800,000.00			7,800,000.00
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	5,468,800,000.00	804,442,672.00	(590,061,115.91)	5,683,181,556.09
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			18,730,969.74	18,730,969.74
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			(5,512,879,356.72)	(5,512,879,356.72)
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				

Зарласан ногдол ашиг				
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	5,468,800,000.00	804,442,672.00	(6,084,209,502.89)	189,033,169.11

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

“Шинэ мөрөн худалдааны төв” ХХК-ийн эрхэм зорилго нь “Худалдаа эрхлэгч нарыг тохилог, стандартын шаардлага хангасан орчин үеийн шийдэл бүхий ажлын байраар хангахын зэрэгцээ худалдан авагчдын сэтгэлд нийцсэн хэрэгцээт барааг нэг дороос сонгон үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино” гэсэн байна.

Нийт 6048 метр квадрат талбайд бараа болон хүнсний павильон, задгайлангуу түрээсэлж, бүх төрлийн бараа үйлчилгээний төвлөрсөн худалдаа үйлчилгээг ард иргэддээ үзүүлж байна. Тус худалдааны төв нь дараах онцлог давуу талтай.

Худалдааны төвийн зохион байгуулалт:

1 дүгээр давхарт 6.3 метр квадрат талбай бүхий 60 ширхэг павильон, 52 метр квадрат талбай бүхий 11 ширхэг хүнсний бөөний худалдааны өрөө, Говь хангай мебель тавилгын дэлгүүр, цайны газар, үсчин гоо сайхан, гар утас түүний дагалдах хэрэгсэл, барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээ, бичигхэрэг, гоо сайхан, ахуйн бараа, гадна талд 10 павильон, бөөний төв 2 дугаар давхарт бараа бэлэн хувцасны 172 ширхэг павильонуудтай гэрээ байгуулан ажиллаж байсан ба 2025 оны 03 сар тухайн барилга шатаж, барилгад үйл ажиллагаа явуулж байсан бүх зогссон.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

“Шинэ мөрөн худалдааны төв” ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигч нь Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмүү өртгийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Шинэ мөрөн худалдааны төв” ХХК нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Шинэ мөрөн худалдааны төв” ХХК нь Нью-баланс аудит ХХК-тай 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” боловсруулах 23/03/56 дугаартай гэрээг байгуулан ажилласан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлд ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа НББОУС, СТОУС, Засгийн газар, Сангийн яам, удирдах бусад байгууллагаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Шинэ мөрөн худалдааны төв” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,507,503.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	106,140.1	166.5	(105,973.6)
Авлага	41,432.4	37,888.6	(3,543.8)
Бараа материал	103,171.7	-	(103,171.7)
Үндсэн хөрөнгө	5,192,084.3	-	(5,192,084.3)
Биет бус хөрөнгө	104,050.0	1,320.0	(102,730.0)
Нийт хөрөнгө	5,546,878.5	39,375.1	(5,507,503.4)
Өр төлбөр	40,193.7	26,838.7	(13,355.0)
Эздийн өмчийн дүн	5,468,800.0	5,468,800.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	804,442.7	804,442.7	-
Хуримтлагдсан ашиг	(766,557.8)	(6,260,706.3)	(5,494,148.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,546,878.5	5,544,030.9	(5,507,503.4)

Тайлант онд тус байгууллагын барилга шатсантай холбоотой аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 4,636,616.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 1,688,695.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэлээс хассан байна.

3.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2025 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тухайн байгууллага шатсан тул худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

3.6. Үндэсний аудитын газраас ирүүлсэн ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

Судалгааны хувьд тухайн байгууллагын үйл ажиллагаатай хамааралгүй байна.

Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнд илсэн зөрчилтэй асуудлуудыг аудитын тайланд тусгасан болно.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Шинэ мөрөн худалдааны төв” ХХК -ийн 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани/ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер тилли “Далайван аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж анхан шатны чанарын хяналтыг захирал, аудитор Д.Мягмарсүрэн, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Чагнаадорж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 741,555.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 14,831.1 мянган төгрөгөөр, Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,381.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 33 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал гараагүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд авсан судалгааны үр дүн:

Төрийн хэмнэлтийн хүрээнд автомашин, орлогч дарга, цахим худалдан авалттай холбоотой судалгаа авахад автомашин хэрэглэдэггүй, орлогч дарга ажиллуулаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, худалдан авалттай зөрчилтэй асуудал гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4,000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан ба алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хийсэн ажил, үр дүнгийн талаар товч бичнэ. Хэрвээ асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн бол биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгана. Биелэлт хангалтгүй бол тайлант оны буруу илэрхийллийн дүнд оруулна.

Тайлант онд тухайн байгууллагад завсрын аудит ороогүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аудитаар нийт 32,103.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 541,102.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 16,756.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 290,566.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлж, 233,780.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	16,756.0			
Албан шаардлага	5	290,566.0			
Зөвлөмж	2	233,780.0			
Нийт дүн	9	541,102.0			

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 71,072.9 төгрөгийн зөрчил илэрснээс 16,922.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 54,149.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өглөг татварын байлангийн өглөгийн үлдэгдэлтэй 16,922.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт зөрчигдөж байна. Аудитаар илрүүлсэн 42.7 сая төгрөгийн зөрчлөөс 18.5 сая төгрөг нь материалаг зөрчил бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага.

Албан шаардлага хүргүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Гүйцэтгэх захирал, нягтлан бодогчид.

1. Авлагын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Тайлангийн хугацааны эцэст 37,888.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн авлагатай тооцоо нийлж эргэн төлөгдөх эсэх дээр анхаарал хандуулах

2. Орлогын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: "Татварын тайлангийн орлого, санхүүгийн тайлангийн орлого 16.261.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 5.1.5-д "хэмжигдэхүйц байх"; 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 65 дугаар зүйл НББ-ын зарчим дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт зөрчигдөж байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг сар бүрээр тулгаж татварын баримтыг нөхөн олгож байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийн тооцооллын алдаа	1	16,922.2			1	16,922.2	1	16,922.2
Дүн	1	16,922.2			1	16,922.2	1	16,922.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	37,888.6					1	37,888.6
Орлого дутуу тайлагнасан.	1	16,261.2					1	16,261.2
Дүн	2	54,149.8					2	54,149.8